



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар A/57

Арвайхээр


Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх  
арга хэмжээний зардал батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2014 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоол, “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 09/10 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд нийт 162.400.000 (нэг зуун жаран хоёр сая дөрвөн зуун мянга) төгрөг зарцуулж, биелэлтийг тайлагнахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Т.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100138

Аймгийн Засаг даргын 2019... оны .01  
дугаар сарын 19...ны өдрийн 1/37 дугаар  
захирамжийн хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫГ 2019 ОНД ХАМГААЛАХ, НӨХӨН  
СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭ ТҮҮНИЙ ЗАРДАЛ

| №        | Хэрэгжүүлэх ажлууд<br>/товч тодорхой/                                                                                    | Тоо хэмжээ                               | Зардал /мян.<br>төг/ |
|----------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------|----------------------|
| 1        | Ногоон байгууламжийн хөрс бэлтгэх зориулалттай өргөгч машин авах                                                         | 1                                        | 83.000.0             |
| 2        | Ойгоос мод шилжүүлэн суулгах машин авах үнийн зөрүү                                                                      | 1                                        | 20.000.0             |
| 3        | Арвайхээр сумын агаар, хөрсний бохирдлын нарийвчилсан судалгаа хийх                                                      | 1                                        | 6.000.0              |
| 4        | Ховор амьтны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авах                                                                | Агнуурын бүс нутагт                      | 4.000.0              |
| 5        | Говь, тал хээрийн бүсэд булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалах                                                        | 10                                       | 20.000.0             |
| 6        | Зорилтот жилийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцох | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 10.000.0             |
| 7        | Арвайхээр суманд баригдах цэцэг тарих зориулалттай өвлийн хүлэмж барихад дэмжлэг үзүүлэх /үлдэгдэл зардал/               | 1                                        | 12.000.0             |
| 8        | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр сургалт, туршлага судлуулах                                            | 1                                        | 7.400.00             |
| Нийт дүн |                                                                                                                          |                                          | 162.400.000          |